



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 992

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 73,713.4 мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын хэрэгжилт 71.6 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байх тул албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллахыг “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч В.Дарханбаатарт үүрэг болгосугай.

2.“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч В.Дарханбаатарт санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах;

3.2Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 84 дүгээр тогтоолоор баталсан үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-ийн “Үл хөдлөх хөрөнгө, байр талбай түрээслэх” гэснийг “үндсэн үйл ажиллагаатай холбоотой үл хөдлөх хөрөнгө, байр талбай түрээслэх” гэж нэмэлт өөрчлөлт оруулахыг Хувьцаа эзэмшигчид тавьж шийдвэрлүүлэх;

3.3.Худалдан авах ажиллагаанд Сангийн сайдын тушаалаар баталсан 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

3.4.Үйлдвэрийн газрын дүрэм шинэчлэн батлагдахаас өмнө олсон түрээсийн 62,7 сая төгрөгийн орлогоос 40 хувь, 25.1 сая төгрөгийг 2022 оны санхүүгийн жилд багтаан Улсын төсөвт төвлөрүүлэх;

3.5. Үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 800 м2 авто зогсоолын түрээслэгчийг журмын дагуу сонгон шалгаруулах ажлыг 2022 оны эхний хагас жилд багтаан хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, түрээсийн орлогын зохих хувийг Улсын төсөвт төвлөрүүлэх;

3.6 Засгийн газрын 2020 оны Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай 10 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах;

132002527

3.7. Үйлдвэрийн газрын 2014 онд, хамтран ажиллах гэрээний дагуу, “Эн Эм Си Жи” ХХК-тай холбоотой үүссэн 18.0 сая төгрөгийн авлагыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх;

3.8. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллого явагдаж байгаатай холбогдуулан үйлдвэрийн газрын хөрөнгөд бүртгэлтэй үнэт эдлэлийн шинж агуулсан байж болзошгүй зарим хөрөнгийн бодит үнэ цэнийг шинжлэн тогтоох, бүртгэх асуудлыг мэргэжлийн байгууллагатай хамтран шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах;

3.9. Үйлдвэрийн газрын дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4-т “...өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг үйлдвэрийн газрын ерөнхий нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ” гэснийг баримтлан ажиллаагүй ерөнхий нягтлан бодогч Г.Төрбатад холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцох.

4. Төрийн өмчийн эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, төрийн өмчийн ашиглалт хамгаалалт, хадгалалтад хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т, үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн
332 дугаар тогтоолын хавсралт



“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газарт хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /сая.төгрөг/	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй	Г.Төрбат /ерөнхий нягтлан бодогч/	48.6	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 8.1.1-д заасан тендер шалгаруулалтын журам болон 52.1.12-т заасан худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх зорилготой веб хуудас хөтлөх, тендерийн урилга, бусад мэдээлэл тавих арга хэлбэрийг тогтоох тухай заалтуудыг биелүүлж ажиллах;
2	Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын 7 дахь заалтыг мөрдөж ажиллаагүй	В.Дарханбаатар /захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч/, Г.Төрбат /ерөнхий нягтлан бодогч/	150 м2	Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах
3	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28.5 дахь заалт, захиралтай байгуулсан контрактын 3 дугаар зүйлийн 3.2.10 дахь заалтыг мөрдөж ажиллаагүй	В.Дарханбаатар /захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч/, Г.Төрбат /ерөнхий нягтлан бодогч/	25.1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь заалтыг мөрдөж ажиллах
4	Дотуур байрны зориулалтаар түрээсэлж буй байр талбайн тарифыг тогтоон мөрдөж ажиллаагүй	В.Дарханбаатар /захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч/, Г.Төрбат/ерөнхий нягтлан бодогч/		Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх заалт, Захиралтай байгуулсан контрактын 3 дугаар зүйлийн 3.2.9 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах
НИЙТ ДҮН			73.7	